



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/132

Мандалговь

Коронавирусын халдварын болзошгүй  
эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр  
авах арга хэмжээний тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, Улсын Онцгой комиссын 2021 оны 02 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 02 дугаар албан даалгавар, Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/143 дугаар захирамж, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны А/10 дугаар тушаал, 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 01/140 тоот албан бичгээр ирүүлсэн ажлын чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шинэ төрлийн коронавирусийн халдварын болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж, улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан байгууллагын ажилтан, албан хаагчдыг 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс 04 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд гэрээс нь цахимаар ажиллуулан, албан үүргийг гүйцэтгүүлсүгэй.

2. Хүүхэд хамгааллын мэргэжлийн\* ангийн эргүүл, жижүүрийн хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Ажилтан, албан хаагчдын ажилласан цагийг үндсэн цагаар ажилласанд тооцон цалинжуулахыг Нягтлан бодогч /С.Чинбат/-д зөвшөөрсүгэй.

4. Коронавирусын халдварын болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг чанартай зохион байгуулан, мэргэжлийн байгууллагын зөвлөмж, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиж, албаны бэлэн байдлыг хангаж ажиллахыг нийт ажилтан, албан хаагчдад үүрэг болгосугай.

5. Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, өдөр бүр танилцуулж ажиллахыг Хүүхэд хамгааллын мэргэжилтэн, ахлагч /Б.Цэцэг/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

491190066